

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ариг гал ХК-ийн

Өөрчлөлтгүй дүгнэлт

Бид Ариг гал ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогууд, бусад тайлбар тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалтгүй дүгнэлтийн хувьд Ариг гал ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангуудад санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулах хариуцлагыг болон залилан эсвэл алдаанаас шалтгаалан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг хангахад шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтын үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний хүлээх хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын сонголт нь санхүүгийн тайлангууд нь аливаа заль мэх, алдаанаас шалтгаалан материалагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлүүдийн үнэлгээг багтаасан аудиторын шийдлээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэн толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэнэ.

Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой байдал, санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгыг үнэлэх ажлуудыг багтаана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалтгүй дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

АЯА ТАКС АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2025 ОНЫ ДУГААР
САРЫН-НЫ ӨДӨР

АУДИТ ХИЙСЭН "АРИГ ГАЛ" ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН
ТЭНЦЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	2023	2024	Аудитлагдсан
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,020,640,505	1,556,016,703	1,556,016,703
Дансны авлага	64,580,847,123	78,967,939,776	78,967,939,776
Татвар, НДШ-ийн авлага	272,691,402	275,713,693	275,713,693
Бараа материал	26,937,938	26,926,238	26,926,238
Эргэлтийн хөрөнгийн дүн	66,901,116,968	80,826,596,410	80,826,596,410
Эргэлтийн бус хөрөнгө			-
Үндсэн хөрөнгө	2,419,355,085	2,296,583,031	2,296,583,031
Биет бус хөрөнгө	14,994,480	13,358,719	13,358,719
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	509,333,043	509,333,043	509,333,043
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	18,344,003,635	18,474,485,538	18,474,485,538
	21,287,686,243	21,293,760,331	21,293,760,331
НИЙТ ХӨРӨНГӨ	88,188,803,211	102,120,356,740	102,120,356,740
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	70,152,571,279	82,136,721,683	82,136,721,683
Цалингийн өглөг	18,189,913	18,880,332	18,880,332
Татварын өглөг	31,056,098	6,413,246	6,413,246
НДШ өглөг			-
Бусад богино хугацаат өр төлбөр	4,122,416,086	3,509,320,184	3,509,320,184
УОО	391,102	391,102	391,102
Бусад урт хугацаат өр төлбөр	950,407,427	1,153,229,871	1,153,229,871
Богино хугацаат өр төлбөр	75,275,031,905	86,824,956,418	86,824,956,418
Нийт өр төлбөрийн дүн	75,275,031,905	86,824,956,418	86,824,956,418
Эзэмшигчдийн өмч			
Өмч	347,932,000	347,932,000	347,932,000
Халаасны хувьцаа	(21,469,300)	(25,890,800)	(25,890,800)
Нэмж төлөгдсөн капитал	(394,512,744)	(528,915,454)	(528,915,454)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,683,611,872	6,683,611,872	6,683,611,872
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6,298,209,477	8,818,662,704	8,818,662,704
	12,913,771,305	15,295,400,323	15,295,400,323
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	88,188,803,211	102,120,356,740	102,120,356,740

АУДИТ ХИЙСЭН "АРИГ ГАЛ" ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2024	Аудитлагдсан
Борлуулалтын орлого (цэвэр)		-
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-
Түрээсийн орлого	1,113,583,242	1,113,583,242
Хүүний орлого	49,221,080	49,221,080
Ногдол ашгийн орлого	12,639,791,213	12,639,791,213
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	1,890,926,706	1,890,926,706
Бусад зардал	7,864,654,692	7,864,654,692
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,047,014,137	4,047,014,137
Орлогын татварын зардал	1,268,901,229	1,268,901,229
Татварын дараах ашиг (алдагдал)	2,778,112,907	2,778,112,907
Зогсоосон ү/а-ны тат-ын дараах ашиг (алдагдал)		
Тайлангийн үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,778,112,907	2,778,112,907
Орлогын нийт дүн	2,778,112,907	2,778,112,907

АУДИТ ХИЙСЭН "АРИГ ГАЛ" ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмч	халаасны хувьцаа	НТК	хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	нийт дүн
20 оны 12-р сарын 31	347,932,000	(10,398,830)	(120,025,202)	6,683,611,872	4,017,130,897	10,918,250,738
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					2,505,393,040	2,505,393,040
Өмчид гарсан өөрчлөлт		(11,070,470)	(274,487,542)			(285,558,012)
Зарласан ногдол ашиг					(224,311,760)	(224,311,760)
20 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	347,932,000	(21,469,300)	(394,512,744)	6,683,611,872	6,298,212,177	12,913,774,005
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал					2,778,112,907	2,778,112,907
Өмчид гарсан өөрчлөлт		(4,421,500)	(134,402,710)			(138,824,210)
Зарласан ногдол ашиг					(257,659,680)	(257,659,680)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	347,932,000	(25,890,800)	(528,915,454)	6,683,611,872	8,818,665,404	15,295,403,023

АУДИТ ХИЙСЭН "АРИГ ГАЛ" ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2024	Аудитлагдсан
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	36,004,995,815	36,004,995,815
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	277,410,426	277,410,426
Бусад мөнгөн орлого	35,727,585,388	35,727,585,388
Мөнгөн зарлагын дүн (-)	1,012,348,912	1,012,348,912
Ажиллагчдад төлсөн	277,602,947	277,602,947
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	65,752,000	65,752,000
Бараа материал худалдан авахад төлсөн	5,173,410	5,173,410
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,944,524	11,944,524
Татварын байгууллагад төлсөн	211,853,772	211,853,772
Бусад мөнгөн зарлага	440,022,258	440,022,258
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	34,992,646,903	34,992,646,903
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	11,375,812,092	11,375,812,092
Хүлээн авсан ногдол ашгийн орлого	11,375,812,092	11,375,812,092
Мөнгөн зарлагын дүн (-)	610,909	610,909
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	610,909	610,909
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,375,201,183	11,375,201,183
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	46,832,471,887	46,832,471,887
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	46,554,613,000	46,554,613,000
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	277,858,887	277,858,887
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(46,832,471,887)	(46,832,471,887)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(464,623,802)	(464,623,802)
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,020,640,505	2,020,640,505
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,556,016,703	1,556,016,703

ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ - Хэвтээ ба босоо шинжилгээ

Үзүүлэлт	Өмнөх оны дүн		Тайлант оны дүн		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН						
Түрээсийн орлого	1,277,651,147		1,113,583,242		164,067,905	-13%
Хүүний орлого	13,146,958	-	49,221,080		36,074,122	274%
Ногдол ашгийн орлого	10,635,380,139		12,639,791,213		2,004,411,074	
Ерөнхий удирдлагын зардал	1,890,177,872		1,890,926,706		748,834	0%
Бусад зардал	7,530,610,033		7,864,654,692		334,044,660	
Татварын төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	2,505,390,340		4,047,014,137		1,541,623,796	62%
Орлогын татварын зардал			1,268,901,229		1,268,901,229	
Татварын дараах ашиг /алдагдал/	2,505,390,340		2,778,112,907		272,722,567	11%
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН						
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,020,640,505		1,556,016,703		(464,623,802)	-23%
Дансны авлага	64,580,847,123		78,967,939,776		14,387,092,652	22%
Татвар, НДШ-ийн авлага	272,691,402		275,713,693		3,022,291	1%
Бараа материал	26,937,938		26,926,238		(11,700)	0%
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,901,116,968		80,826,596,410		13,925,479,442	21%
Үндсэн хөрөнгө	2,419,355,085		2,296,583,031		(122,772,054)	-5%
Биет бус хөрөнгө	14,994,480		13,358,719		(1,635,762)	-11%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	18,344,003,635		18,474,485,538		130,481,903	1%
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	509,333,043		509,333,043		-	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	21,287,686,243		21,293,760,331		6,074,087	0%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	88,188,803,211		102,120,356,740		13,931,553,529	16%
Дансны өглөг	70,152,571,279		82,136,721,683		11,984,150,404	17%
Цалингийн өглөг	18,189,913		18,880,332		690,419	4%
Татварын өглөг	31,056,098		6,413,246		(24,642,852)	-79%
Урьдчилж орсон орлого	391,102		391,102		-	
Бусад богино хугацаат өр	4,122,416,086		3,509,320,184		(613,095,903)	-15%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	74,324,624,479		85,671,726,547		11,347,102,068	15%
Бусад урт хугацаат өр	950,407,427		1,153,229,871		202,822,444	21%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	950,407,427		1,153,229,871		202,822,444	21%
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	75,275,031,905		86,824,956,418		11,549,924,512	15%
Өмч	6,615,561,828		6,476,737,618		(138,824,210)	-2%

Төрийн	-	-	-	-
Хувийн	347,932,000	347,932,000	-	
Хувьцаат	-	-	-	
Халаасны хувьцаа	(21,469,300)	(25,890,800)	(4,421,500)	21%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,683,611,872	6,683,611,872	-	
Нэмж төлөгдсөн капитал	(394,512,744)	(528,915,454)	(134,402,710)	34%
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	6,298,209,477	8,818,662,704	2,520,453,227	40%
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,913,771,305	15,295,400,323	2,381,629,017	18%
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	88,188,803,211	102,120,356,740	13,931,553,529	16%

ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ - Харьцааны шинжилгээ

Гол харьцаанууд	Тооцоолол	Босго	Тайлант жил	Өмнөх тайлант жил	Өөрчлөлт
Хөрвөх чадварын шинжилгээ					
Эргэлтийн харьцаа	<i>БХХөр / БХӨТ</i>	>1	0.9	0.9	0.04
Түргэн хөрвөх харьцаа	<i>(Эргэлт.хөр - БМ) / БХӨТ</i>		0.9	0.9	0.04
Мөнгөн хөрөнгийн харьцаа	<i>(МХ + БХХО) / БХӨТ</i>		0.0182	0.02719	- 0.0090
Санхүүгийн чадварын харьцаа					
Өр эздийн өмчийн харьцаа	<i>Нийт өр төлбөр / Нийт эздийн өмч</i>	<1	5.7	5.8	- 0.2
Өрийн харьцаа	<i>Нийт өр төлбөр / Нийт хөрөнгө</i>		0.9	0.9	- 0.0
Хүү төлөх чадвар	<i>Хүү ба татварын өмнөх ашиг / Хүүгийн зардал</i>				
Ашигт ажиллагааны харьцаа					
Цэвэр ашгийн харьцаа	<i>Татварын дараах ашиг / Нийт орлого</i>	>0	-	-	-
Нийт ашгийн харьцаа	<i>(Борлуулалт-ББӨ) / Борлуулалт</i>		0%	0%	0%
Хөрөнгийн өгөөж	<i>Цэвэр ашиг / Нийт хөрөнгө</i>		0.03	0.03	- 0.00
Өмчийн өгөөж	<i>Цэвэр ашиг / Хувьцаа эзэмшигчдийн өмч</i>		0.18	0.19	- 0.01

Зарим тохиолдолд, харьцааны шинжилгээ хийхэд тайлант жилийн эцсийн үнэ цэнэ нь үнэн зөв мэдээлэл болж чаддаггүй. Учир нь улирлын хүчин зүйлсээс хамаарч тайлант хугацааны эцсийн байдлаар зарим дансуудын үлдэгдэл өсч эсвэл буурч байдаг. Энэ өөрчлөлт нь харьцааны үр дүнд нөлөөлнө. Тиймээс, дундаж үзүүлэлтийг харьцааны шинжилгээнд ашиглах нь зохистой байдаг.

Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, аргын сонголт зэрэг нь харьцааны шинжилгээнд чухлаар нөлөөлдөг.

Шинжилгээний үр дүн:

Тус байгууллагын хөрвөх чадварын харьцаа, санхүүгийн чадварын харьцаа, ашигт ажиллагааны харьцаа өмнөх онтой харьцуулахад сайжирсан байна.

АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ТАЙЛБАР ТОДРУУЛГА

1. Компанийн үйл ажиллагааны тухай

Байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо Зайсангийн гудамж, Чингисийн өргөн чөлөө, өөрийн байранд. Утас: 342814, 342549. Цахим хаяг: ariggal.sankhuu@yahoo.com

Өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл: Хувьцаат компани, Үл Хөдлөх Хөрөнгийн түрээс, худалдааны зуучлал, тоног төхөөрөмжийн түрээс

Харилцагч санхүү, НД, татварын байгууллага: Хан-Уул дүүргийн санхүү, төрийн сангийн хэлтэс. Хан-Уул дүүргийн татварын хэлтэс, Том татвар төлөгчийн газар, Хан-Уул дүүргийн Нийгмийн Даатгалын хэлтэс.

Тайланг хамарсан хугацаа: 2024 оны 1 сарын 01-ээс 2024 оны 12 сарын 31-ийг дуустал

“Ариг гал” ХК нь анх “Ээрмэл”-ийн үйлдвэр нэртэйгээр 1981 онд ОХУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар байгуулагдсан. Монголын ноосны салбарын Нэхмэл, Сүлжмэлийн 1, 2-р үйлдвэрүүд, Улаанбаатар, Эрдэнэт, Дорнодын хивсний үйлдвэрүүдийг цэвэр болон хагас ноосон утсаар 100% хангах чиглэлээр жилдээ 3500 тн 3-42 номерын хагас болон цэвэр ноосон ээрмэл хийх хүчин чадалтайгаар ашиглалтад орсон болно.

1990 он хүртэл бүрэн хүчин чадлаараа ажиллаж, дотоодын ноосны салбарын үйлдвэрүүдийг бүрэн хангаж байснаас гадна цэвэр ноосон ээрмэлийн 40-өөд хувийг Болгар, Афганистан улсад экспортод гаргаж байлаа.

1991 оны 6 сард МУ-н ЗГ-н ӨХК-н 61 тоот тогтоолоор хувьчлагдаж төрийн оролцоогүй 100%-н “Хувьцаат Компани” хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд одоо 7332 хувьцаа эзэмшигчтэй, хувьцааны 60 гаруй хувийг компанийн ажиллагчид эзэмшдэг.

1993-1997 онуудад АНУ-тай хамтарсан хонины ноосон сүлжмэлийн үйлдвэрлэлийн “МоАмКо” ХХК-ийг байгуулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргасан. Мөн 1997 онд Итали улстай хамтарсан ноолуурын хялгас ялгах “Монгол Кашмер Файн” ХХК-ийг байгуулж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлсэн.

Шинээр байгуулсан хамтарсан компаниуддаа мэргэшсэн ажилчидаа шилжүүлэн ажиллуулснаар нэг ч ажилчныг ажлын байргүй үлдээгээгүй хадгалж үлдсэн.

1997 онд угаах үйлдвэрлэлийн чиглэлээр “Мон Мяндал” ХХК-ийг 2000 онд тэмээний ноосны хялгас ялгах болон ээрэх шугамыг 2002 онд нэхмэлийн үйлдвэрлэлийг, 2004 оноос сүлжмэлийн утас ээрэх шугамыг тус тус суурилуулж, “Мон Мяндал” ХХК-ийг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагааг өөрчлөн шинэчиллээ.

2009 онд “Ариг Гал” ХК нь 100% хөрөнгө оруулалттай “Кашмер Холдинг” ХХК-ийг байгуулж нэхэх, сүлжих, зөөлөн оёдол, ширмэл, утас үйлдвэрлэх үйлдвэрлэлийг 800 гаруй ажилтантайгаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод гадаадын зах зээлд гаргаж байна.

2007-2014 онуудад ээрэх, сүлжих үйлдвэрлэлийг өргөтгөх, улмаар нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний гүйцэтгэн боловсруулах иж бүрэн үйлдвэрлэлийг бий болгож, бүтээгдэхүүний хэрэглээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилгоор европын өндөр технологийг бий болгож 100% зөвхөн өөрийн хөрөнгөөр бий болгож чадсан Монгол Улсын цорын ганц компани болж чадлаа.

2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа хэлэлцэж шийдвэрлэснээр 2014 оны 06 дугаар сараас эхлэн компанийн оноосон нэрийг “Ариг Гал” ХК болгож өөрчилсөн болно.

Тус компанийн үндсэн үйл ажиллагаа нь барилга, инженерийн байгууламжийн үйлчилгээ, барилгын түрээс, барилгын засвар, шохойн чулуу олборлох хөрөнгө оруулалт хийх гэх мэт менежментийн толгой компаниар ажиллаж байна.

2. Санхүүгийн тайланг бэлтгэсэн тухай

а) Санхүүгийн тайлангийн нийцэл

Компанийн санхүүгийн тайлан нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх зааврын дагуу бэлтгэгдсэн.

б) Тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг Монгол үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Аудитлагдсан санхүүгийн тайланг бэлтгэхдээ өмнөх оны аудитлагдсан үлдэгдэлтэй зэрэгцүүлсэн.

в) Тасралтгүй байх зарчим

2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан нь тасралтгүй байх зарчим дээр үндэслэгдсэн.

г) Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн тухай

Компани нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх үйл ажиллагаандаа “Поверсофт” программын “WINDOWS”-ийн орчинд сайжруулсан хувилбар болон бусад хэрэглээний программыг ашиглаж байна.

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого

а) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө болон банкны харилцах дансны үлдэгдлийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөр тайлагнасан. Үндэсний валютыг нэрлэсэн үнээр, гадаад валютыг тайлангийн тасалбар болгосон өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар монгол төгрөгт хөрвүүлж тайлагнасан.

б) Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан нь тайлангийн хугацааны туршид гарсан үндсэн болон хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг харуулдаг. Мөнгөн гүйлгээний тайланг шууд аргаар бэлтгэсэн.

в) Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ

Ажил гүйлгээ гарсан өдрийн тайлагнах валют болон гадаад валютын хоорондын ханшаар гадаад валютын дүнг монгол төгрөгөөр тооцох замаар гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тайлагнах валютаар илэрхийлсэн. Гадаад валютаар хийгдсэн өр төлбөрийн үлдэгдэл болон хүүний гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар монгол төгрөгт хөрвүүлж бүртгэнэ. Түүхэн өртгөөр тодорхойлогдсон гадаад валютаарх мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан тухайн өдрийн албан ханшаар монгол төгрөгт хөрвүүлж бүртгэнэ. Монгол банкнаас зарласан албан ханш өөрчлөгдөх тухай бүр гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд ханшны тэгшитгэл хийх ба үүссэн зөрүүг гадаад валютын ханшны тэгшитгэлийн олз, гарзаар хүлээн зөвшөөрнө гэж заасны дагуу бүртгэсэн байна.

г) **Авлага**

Авлагыг хүлээн авахаар урьдчилан тооцсон хэмжээгээр үнэлсэн ба найдваргүй авлагын хасагдуулга тооцдоггүй. Тайлант жилд авлагын үлдэгдэлд найдваргүй авлагын хасагдуулга тооцоогүй.

д) **Бараа материал**

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно. Бараа материалаа дундаж өртгийн аргыг ашиглан зарлага болгодог. Үйлдвэрлэсэн буюу бэлэн бүтээгдэхүүний өртөгт үйлдвэрлэлд олгосон түүхий эд материалын, үйлдвэрлэлийн ажиллагсдын цалин хөлсний, үйлдвэрлэлтэй холбоотой гарсан бусад нэмэгдэл зардлууд багтдаг. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг тооцохдоо түүнд багтсан түүхий эд материалын өртгийг дундаж өртгийн аргаар тооцдог.

е) **Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хэмжинэ. Үндсэн хөрөнгийн өртөгт худалдан авсан үнэ, түүнийг бэлтгэхтэй холбогдон гарсан аливаа шууд зардал орно. Үндсэн хөрөнгө нь өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан дансны цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа түүний анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг данснаас хасах бөгөөд хөрөнгийг данснаас хассанаас үүссэн аливаа олз, гарзыг орлогын тайланд тусгадаг.

Компани үндсэн хөрөнгөндөө Монгол улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-д заасан ашиглалтын хугацааг баримтлан шулуун шугамын аргаар элэгдэл тооцсон.

ё) **Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хэмжинэ. Биет бус хөрөнгийн анхны өртөгт худалдан авалтын өртөг, хөрөнгийг тухайн зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой холбоотой шууд нэмэлт зардлууд багтана. Биет бус хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа хуримтлагдсан хорогдол ба хуримтлагдсан үнэ цэний бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь илэрхийлнэ.

ж) **Өр төлбөр**

Өр төлбөр нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авсны төлөө бусдын өмнө хүлээж буй хариуцлага буюу ирээдүйд төлөх бодит өртгөөрөө санхүүгийн тайланд тусгагдана. Холбогдох хөрөнгө ба зардлыг хүлээн зөвшөөрсөн үед өр төлбөрийг бүртгэнэ.

з) **Эздийн өмч**

Эздийн өмч нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,479,320 ширхэг энгийн хувьцаанаас бүрддэг. Хувьцааг нэрлэсэн үнээр бүртгэсэн. 2022 онд компани 12,560 ширхэг хувьцаа халаасалсан ба үүнд нийт 36,399,890 төгрөгийг зарцуулсан. 2015 оноос хувьцаа халааслахдаа нэрлэсэн үнийн аргаар бүртгэсэн тул 35,143,890.17 төгрөгийг тайлант хугацаанд нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэсэн залруулгыг хийсэн.

и) **Дахин үнэлгээний нөөц**

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн байвал өсөлтийг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайлангийн өмчийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Гэхдээ тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг өмнө нь ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрсөн бол тэр хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтийг мөн адил ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан байвал уг

бууралтыг ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Гэхдээ дахин үнэлгээний бууралтыг өмнөх дахин үнэлгээний нэмэгдлийн кредит дүнгийн хэмжээгээр бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч болно. Үндсэн хөрөнгийг данснаас хасах үед дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлагдсан тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

к) **Орлого**

Орлого нь үнэн зөв тодорхойлох боломжтой болон эдийн засгийн үр ашиг нь компанид орох нь тодорхой болсон үед орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг аккрузал суурийг үндэслэн хүлээн зөвшөөрнө. Орлого нь хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж байгаа мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжигдэнэ.

л) **Зардал**

Хөрөнгийн бууралт буюу өр төлбөрийн өсөлттэй холбоотойгоор ирээдүйн эдийн засгийн өгөөжийн бууралт гарсан ба найдвартайгаар хэмжиж болох тохиолдолд зардлыг хүлээн зөвшөөрнө. Зардлыг аккрузал суурийг үндэслэн хүлээн зөвшөөрнө.

м) **Орлогын албан татвар**

Компани нь Монгол улсын татварын хуулиудын дагуу аливаа албан татвараа тооцож бүртгэж тайлагнана.

н) **Санхүүгийн хэрэглүүр**

Санхүүгийн хэрэглүүр гэдэг нь нэг байгууллагын санхүүгийн хөрөнгө, нөгөө байгууллагын санхүүгийн өр төлбөр буюу өмчийг зэрэг өсгөдөг аливаа гэрээ юм. Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өөр байгууллагаас авах гэрээний эрх, эсвэл санхүүгийн хэрэглүүрийг өөр боломжит тааламжтай нөхцөлөөр бусад байгууллагатай солилцох эрхийг санхүүгийн хөрөнгөөр бүртгэдэг.

Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг бусдад өгөх, эсвэл санхүүгийн хэрэглүүрийг боломжит тааламжгүй нөхцөлөөр бусадтай солилцох, гэрээний үүрэг хариуцлага бүхий аливаа өр төлбөрийг санхүүгийн өр төлбөрөөр бүртгэдэг.

Санхүүгийн хэрэглүүрт богино хугацаанд арилжаалахаар, төлбөрийн чадварын удирдлагын зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн деривативууд, зээл ба авлага, төлөгдөх хугацаа хүртэл эзэмшиж байгаа бусад санхүүгийн хэрэглүүр хамаарна.

4. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн тухай

Бид оршин байсан стандартууд ба тайлбартай холбоотой өөрчлөлтүүдийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн болно. Үүнд:

Шинэ болон нэмэлт өөрчлөлт бүхий стандартууд болон тайлбарууд

СТОУС 13 Нэмэлт өөрчлөлт

Жил бүрийн сайжруулалт (2010 - 2012 цикл)

Богино хугацаат Авлага болон

Өр төлбөр

Дээр дурдсан стандартууд болон тайлбарууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад томоохон өөрчлөлт үзүүлээгүй бөгөөд Компанийн санхүүгийн гүйцэтгэл болон санхүүгийн байдалд нөлөө үзүүлээгүй.

5. Үл тасалдах зарчим

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компани нь хэвийн үйл ажиллагааныхаа явцад урьдчилан харах боломжтой хугацаанд хөрөнгөө бүхэлд нь ашиглаж, өр төлбөрөө барагдуулж чадна гэж үзэх СТОУС-ын үл тасалдах зарчмын дагуу бэлтгэсэн болно. Энэхүү үнэлэлтийг

гаргахдаа, Компанийн санхүүгийн байдал, ойрын зорилтууд, үйл ажиллагааны ашигт ажиллагаа болон санхүүгийн эх үүсвэр авах боломж зэргийг харгалзан үзсэн.

Ариг гал ХК нь үндсэн үйл ажиллагаанаасаа мөнгөний орох урсгалыг зээлийн зарим хэсгийг эргүүлэн төлөхөд зарцуулсан.

Компанийн удирдлага богино хугацааны зээлийн санхүүжилт аваагүй.

Тайлант хугацааны дараах дээр дурдсан арга хэмжээнүүдийн үр дүнд Компанийн удирдлага үл тасалдах зарчмын дагуу тайлангуудыг бэлтгэх нь зүйтэй гэж үзсэн.

Хэрэгжиж эхэлсэн стандартууд

Компани нь санхүүгийн тайландаа эдгээр стандартуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

НББОУС 1	Санхүүгийн тайлангийн толилуулга- Толилуулгын санаачлага ¹
СТОУС 9	Санхүүгийн хэрэглүүрүүд ²
СТОУС 10 болон НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт	Нэгтгэсэн санхүүгийн тайлан. Хараат Компани дахь хөрөнгө оруулалт- Хөрөнгө оруулагч болон хараат компани хоорондын борлуулалт болон Хөрөнгийн хувь оролцоо ¹
СТОУС 10 болон НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт	Нэгтгэсэн санхүүгийн тайлан. Хараат Компани дахь хөрөнгө оруулалт- санхүүгийн тайлан гаргахгүй байх онцгой тохиолдол ¹
СТОУС 11 Нэмэлт өөрчлөлт	Хамтарсан Хэлцэл- Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог бүртгэх ¹
СТОУС 12 Нэмэлт өөрчлөлт	Бусад аж ахуй нэгж дэх хувь оролцооны тодруулга- санхүүгийн тайлан гаргахгүй байх онцгой тохиолдол ¹
СТОУС 14	Зохицуулалтын хойшлогдсон данснууд ¹
СТОУС 15	Харилцагчтай байгуулсан гэрээний дагуух орлого ²
НББОУС 16 болон НББОУС 38 Нэмэлт өөрчлөлт	Үндсэн Хөрөнгө. Биет бус хөрөнгө – Элэгдэл хорогдол тооцох зөвшөөрөгдөх аргыг тохируулах ¹
НББОУС 27 Нэмэлт өөрчлөлт	Тусдаа санхүүгийн тайлан- Тусдаа санхүүгийн тайлан дахь өртгийн арга ¹ Жил бүрийн сайжруулалт(2012 – 2014 Цикл)
² 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно	

Удирдлагууд энэхүү стандарт болон тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөх нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх эсэхийг үнэлж байна.